

**ОЛОН УЛСЫН МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН ЭРДЭМТНИЙ АНХДУГААР ИХ ХУРАЛ.
БЭЛТГЭЛ АЖЛУУД, ШУУДАНГИЙН МАРК,
Б.РИНЧЕН “ХУРАЛД ОРОЛЦОХ ЭРДЭМТДИЙН ТУХАЙ” /1959 он /**

Б. Сарантуяа *



Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал 1959 оны 9 дүгээр сарын 1-нээс 8 хүртэл Улаанбаатар хотод хуралджээ. БНМАУ-ын Тээвэр Холбооны Яамнаас энэ их хуралд зориулж марк хэвлүүлсэн. Шинэ марк хэвлүүлэхэд Тээвэр Холбооны Яам, Гадаад Яам харилцан тохиролцож гэрээлдэг байжээ. Хэл зохиол судлах газар, монгол хэл бичиг судлалын эрдэмтдээс их хуралд зориулсан марк гаргах, маркийн зураг, бичиглэл зэрэгт санаачлага гаргасан нь тодорхой.

Аливаа улсын шуудангийн марк нь тухайн улсынхаа түүх соёл, ахуй амьдрал, түүхэн хөгжилтэй салшгүй холбоотой, биеэ даасан онцгой урлагийн бүтээл болж байдаг.

Олон Улсын Монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хуралд зориулж 1959 оны 9 дүгээр сарын 7-нд “First International Congress of Mongolists 1959” нэртэй Монгол Улсын 32 дахь марк, дэлхийн шуудан харилцаанд орсон. Гүн хэвлэлийн аргаар Улаанбаатар хотод хэвлүүлж, маркийн зургийг зураач Д.Лувсанжамц зуржээ.

“First International Congress of Mongolists 1959” гэсэн бичигтэй 1 сери (багц), дотроо 5 нэрийн, олон өнгө бүхий энэхүү маркны 30, 40, 50, 60 мөнгөний маркууд 36х50 мм хэмжээтэй, 1 төгрөгийн марк нь 26х35 мм хэмжээ бүхий, энэ нэг сери маркийн 30 болон 50, 40 ба 60 мөнгөний маркуудыг хооронд нь холбоотойгоор хэвлэсэн.

Улаанбаатар хотод болсон Олон Улсын Монголч Эрдэмтний анхдугаар их хуралд зориулсан “First International Congress of Mongolists 1959” марк.

* МУИС, Монгол хэл, хэл шинжлэлийн тэнхим



үнэ 30 мөнгө.
Монгол бичиг

үнэ 40 мөнгө.
Соёмбо үсэг

үнэ 50 мөнгө.
Тод үсэг

үнэ 60 мөнгө.
Дөрвөлжин үсэг

үнэ 1 төгрөг.
Шинэ үсэг

Бадамлянхуа цэцгээр чимсэн суурин дээр байрлуулсан чандмань (зэндмэнэ) эрдэнийн дотор монгол бичиг, соёмбо, тод, дөрвөлжин, шинэ үсгээр “монгол” гэдэг үгийг нэг нэгээр нь бичсэн нэг сери, 5 нэрийн (номинал) шуудангийн марк. Тухайн үеийн хэвлэлийн хүчин чадал зэргээс хамаараад маркийн цавууны түрхэлт, жигд биш, өнгө будаг нь нүүсэн, живээлэлт өөр өөр хэмжээтэй, хэд хэдэн өнгөтэй хэвлэгдсэн байдаг.

Монгол шуудангийн маркийн түүхэнд тусгайлан нэг их хуралд зориулан гаргасан марк цөөн тоотой байдаг ч Олон улсын монголч эрдэмтний 11 их хурал хуралдсан эдүгээг хүртэл монгол үсэг бичгийн түүхээс ¹харуулсан, бэлгэ дэмбэрэлийн гүн их утга бүхий анхны их хуралд зориулсан дээрх **ганц марк** байна.

Академич Б.Ринчен “Монгол марк бол монголчуудын утга соёл, эрдэм ухааны чухал өв” гэдгийг тэмдэглэсэн анхны судалгааны өгүүлэл бичиж, маркийн зургийн талаар сонирхолтой санал дэвшүүлэн маркийг судлах явцдаа түүнтэй холбогдох бусад сэдвийг судалж шинжих санааг анхлан бичсэн юм.

Энэхүү “First International Congress of Mongolists 1959” маркийн түүхийн талаар юу мэдэгдэж байна вэ, зураач Д.Лувсанжамц энэ түүхт маркийн эх зургийг зурсан тухайгаа бичиж үлдээсэн үү, анхны их хуралд илтгэлээ хэлэлцүүлсэн, мөн зохион байгуулахад оролцсон, хуралд суусан хүмүүсээс дурсамж яриа бичгээр буюу видеогоор авч баримтжуулан тэр түүхэн хурлын үйл явц, цаг үеийг нарийвчлан тодруулан мэдэж цаг алдалгүй хойч үедээ үлдээх хэрэгтэй болов уугэж бодож байна.

¹Монголчууд хийгээд монголчуудын өвөг дээдсийн хэрэглэж ирсэн үсэг бичгүүдийн тогтолцоог нэгтгэн авч үзвэл хоёр мянгаад жилийн түүхтэй бөгөөд зарим өвөрмиц гажилт зэргийг үл тооцох бөгөөс ерөнхийдөө бичиг үсгээ улам боловсронгуй болгох гэсэн оролдолго, эрмэлзлийн түүх гэж хэлж болно. Энэхүү эрмэлзэл монголчуудын улс төрийн тусгаар тогтнол, соёл иргэншлийн өвөрмиц байдлаа хадгалах гэсэн үндсэн ашиг сонирхолтой нь ямагт нийцэн сүлэлдэж иржээ.

Ц.Шагдарсүрэн, 2001, *Монголчуудын бичиг үсэг*, Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, 169.(XVII) 63 дахь тал.

Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтдэд зориулсан марк дэлхийн шуудан харилцаанд орсноос хойш 57 жил өнгөрчээ. Монголын анхны марк “Элдэв-Очир”- /1924/- өөс хойш есөн арван жил улиран одож 1016 дахь сэдэвт, Монгол Улсын хамгийн отгон марк “Алтай Ятга” 2016 оны 11-р сарын 11-ний өдөр эх орныхоо “нэрийн хуудас” болон дэлхийн шуудан харилцаанд орлоо.

Гурван жилийн дараа анхны их хурлаас хойш 60 жил, 2029 онд 70, 2039 онд 80 жил гээд тэгш ойн жилүүд үргэлжилнэ. Монголыг судлагчдын идэвх санаачлагаар монголч эрдэмтний их хуралд зориулсан 2 дахь марк мэндлэх цаг удахгүй ирнэ гэдэгт итгэж хүлээнэ.

Аливаа түүхэн бичиг баримт тэр цаг үеэ өгүүлж, түүхийг хүүрнэн ярьж байдаг. “Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал” /1959 /маркийн талаар гарч байсан тэр цагийн бичиг баримттай танилцана уу. Баримт бичигт хэрхэн бичсэн тэр хэвээр нь хуулан бичлээ.

Үүний сац энэхүү 3 бичиг баримтын төгсгөлд, уг марк зориулагдсан, Монгол хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурлын бэлтгэл ажлын талаар гарсан МАХН-ын Төв Хорооны 2 тогтоолыг оруулав. Энэ тогтоол тухайн цагийн нийгмийг удирдаж байсан нам засгийн бодлого шийдвэр гэхээсээ илүүтэй, монгол хэл соёлын давтагдашгүй бүтээл туурвилаа үлдээж мөнхөрсөн ахмад эрдэмтдийн маань санаа онооноос эхлэлтэй нь гарцаагүй. Энэ бүгдээс эх хэл соёлоо дээдлэн судлан сурталчлах, дэлхий дахинаа түгээн дэлгэрүүлэхийн төлөө бидний ахмад үе хэрхэн сэтгэл зүтгэл гарган хөдөлмөрлөж байсан нь тод харагдаж байна.

Академич Б.Ринчений “Олон улсын хэл бичгийн эрдэмтний анхдугаар их хурал”-д оролцох гадаадын эрдэмтдийн бүтээлийн талаар их хурал хуралдахын өмнө холбогдох газар бичиж өгсөн тодорхойлолтыг Үндэсний төв архиваас шүүн олж мөн дээрхийн адил уг тодорхойлолтыг бичгийн машинаар бичсэн, их эрдэмтний гараар бичиж зассан зэргийг яг тэр хэвээр нь бичиж орууллаа.

RESUME

The 32nd post mark of Mongolia named as the “First International Congress of Mongolists 1959” for First International Congress of Mongolists which was held in Ulaanbaatar city, Mongolia on September 01, 1959. In the mark, word as “Mongolia” was written by old Mongolian script, Square Script, Tod Script, Soyombo Script and New Script, valued at 30, 40, 50, 60 Mungu and 1 Tugrug, the mark has five names of a series and was made in by deep printing method in Ulaanbaatar city.

Since The Mongolian first post mark was “Eldev - Ochir” (1924), the Mongolian marks were made by 1016 themes for nine decades. The Mongolian youngest mark is “Altai Bow Harp” was entered in the world postal relations for and on behalf of Mongolia on Nov 11, 2016.

НОМ ЗҮЙ

Үндэсний Төв Архив. *Монгол Ардын Намын түүхэнд холбогдох баримт бичгүүд*, 1958, 1959 он.

Үндэсний Төв Архив. *Цахилгаан шуудан холбооны газар*. Данс 310.1959 он.

Үндэсний Төв Архив. *Монгол хэл бичгийн эрдэмтний андугаар их хурал*. Данс 310. 1959 он.

Ч.Болд. *Монгол маркийн түүх*, УБ хот., 2007 он

Х.Гунгаажав. *Шуудангийн марк цуглуулагч нарт тусламж* УБ., 1963 он.

Д.Дашжав. *Монгол марк цуглуулагчдын товч лавлах* УБ, 1993 он.

Б.Ринчен. “*Монголчуудын шуудан, шуудангийн тэмдгийн учир*” /1958 он/ “Утга зохиол сонин”, 1991. № 18.

Б.Ринчен. “*Захидал харилцааны боловсрол чухал болж байна* (“Хөдөлмөр” сонин 1968. 12.12. № 149)

Ц.Шагдарсүрэн. *Монголчуудын бичиг үсэг*, Монгол судлалын эрдэм шинжилгээний бичиг, 2001 он, 169.(XVII)

Б.Н.М.А.Улсын сайд нарын зөвлөлийн шийдвэр
1959 оны 9-р сарын Улаанбаатар хот
4 ний өдөр

Шуудангийн марк
гүйлгээнд оруулах
тухай

Монголч эрдэмтэдийн анхдугаар их хуралд зориулсан /монголын эртний ба одоогийн хэрэглэж байгаа үсгүүдээр галт зэндмэнэ хүрээтэй хийсэн/ 30, 40, 50, 60мөнгө, нэг төгрөгийн үнэтэй бүгд 1530000 ширхэг шуудангийн маркыг 1959 оны 9-р сарын 4-нөөс эхлэн гүйлгээнд оруулахыг Б.Н.М.А.Улсын Тээвэр-Холбооны Яам /Н.Дамдинжав/-д зөвшөөрсүгэй.

Б.Н.М.А.Улсын Сайд нарын зөвлөлийн орлогч дарга
/МОЛОМЖАМЦ /
Хуулбар үнэн: Тогтоол ангийн эрхлэгч
/ДАГВАДОРЖ/

Сайд нарын зөвлөл н.Батмөнх танаа

Монголч эрдэмтэдийн анхдугаар их хуралд зориулан 1 сери таван янзын маркийг монголын эртний ба одоогийн хэрэглэж байгаа үсгээр Тээвэр-Холбооны Яамнаас эрхлэн хэвлүүлсэн бөгөөд тэдгээр маркийг үнийн ялгаагаар тодорхойлбол:


1. 30 мөнгөний үнэтэй марк 300000 ширхэг
2. 40 мөнгөний үнэтэй марк 300000 ширхэг
3. 50 мөнгөний үнэтэй марк 300000 ширхэг
4. 60 мөнгөний үнэтэй марк 300000 ширхэг
5. 1 төгрөгийн үнэтэй марк 330000 ширхэг,
Бүгд 1530000 ширхэг болно.

Энэ маркуудийг 1959 оны 9-р сарын 4-нөөс эхлэн гүйлгээнд оруулах тухай Б.Н.М.А.Улсын Сайд нарын зөвлөлөөр шийдвэр гаргуулж өгөхийг хүсье.

Тээвэр-Холбооны Яамны 1-р орлогч сайд :
/Чимэддорж/

40 40

1958
сарын



МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ
НАМЫН ТӨВ ХОРООНЫ УЛС ТӨРИЙН
ТОВЧООНЫ ХУРЛЫН ТОГТООЛ

№ 321 .

Улаанбаатар
хот

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын
Сайд нарын Зөвлөлийн
ШИЙДВЭР

9 дүгээр сарын
7-ны өдөр

Дугаар 344

Улаанбаатар хот,
МАХН-ЫН ТӨВ ХОРООНЫ УЛС
Төрийн Товчооноос ТОГТООХ нь:
Шуудангийн марк гүйлгээнд

1. Олон улсын маргах тухай бичгийн эрдэмтний хурлыг
Монголч эрдэмтний ах дугаар их хурал зохиулав /монгол эртний байдлаар хөрөгцөж
байгаа үсгүүдээр, галт зөндмөн хээтэй/ хийсэн 30, 40, 50, 60 мөнгө, 1 төгрөгийн үнэтэй бүгд
1530000 ширхэг шуудангийн маркийг 1959 оны 9 дүгээр сарын 7-оос эхлэн, гүйлгээнд гаргахыг
Тээвэр, Холбооны Яам/н. Дамдинжав/-т зөвшөөрсүгэй.
ажлыг хангах комиссыг дор дурдсан бүрэлдэхүүнтэйгээр
баталсугай.

Б.Н.М.А.Улсын Сайд нарын зөвлөлийн орлогч дарга /, Жаргалант сум, Жаргалант сум,
Хуулбар үнэн: Тогтоол ангийн эрдэмтэнд эв, Содном, Ринчия, Ц. Дамдинжав, Ц. Дамдинжав

3. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний хуралд
гаднаадас урьж ирүүлэх хүмүүсийн тухай боловсруулахыг
комисст даалгасугай.

4. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтний хурлын
бүхий л бэлтгэл ажлыг урьдас өдөр хангахын тулд хол-
богдох яам, албан газар даалгах нь:

а/олон улсын, монгол хэл бичгийн эрдэмтний хурлыг
эрдэм шинжилгээний ажлын өндөр амжилтаар угтахыг тус
улсын монгол хэл бичгийн эрдэмтэн сэхээтэнд уриалахаар
гадна уул хурлыг эрдэм шинжилгээ, зохион байгуулалтын
талар дээд хэмжээнд явуулахыг ИУДБ хүрээлэнд даалга-
сугай.

б/ олон улсын, монгол хэл бичгийн хуралд уриг ирүү-
лах гаднадын монголч эрдэмтэнд үзүүлэх үзмэрийн зүгсийг
эртнээс бэлтгөвөл зохих, үүнд: олон музей, үзмэрийн газ-
рын дотоод байдлыг эмх цэгцтэй, цэвэр үзэмжтэй болгох,

үзмэрийн элдэв зүйлд хийсэн тайлбар зүүлт зэргийг үг үсгийн талаар дахин хянан үзэж, буруу зүйлийг засаж, дутууг нөхөн гүйцэтгэх зэргээр бэлтгүүлбэл зохион дээр Өрдэнэ зуу, Чойжин ламын сум музей, хааны ордон музейг тусгай төлөвлөгөө ёсоор 1959 оны 6-р сарын нэгний дотор багтаан салбэр засвар хийж шинэтгэн, үзмэрт бэлтгэсэн байхыг Соёлын яам /н.Сосорбарам/-д даалгасугай.

н/ олон улсын, монгол хэл бичгийн эрдэмтний хуралд мөн 1960 онд болох олон улсын дорно дахины судлалтны 25 дугаар хуралд зориулж хэвлэсэн зүйлийг худалдан борлуулахыг Худалдааны яам /н.Дэлгэржав/-т даалгасугай.

г/ олон улсын, монгол хэл бичгийн эрдэмтний хуралд зориулж хэвлүүлэх эрдэм шинжилгээний ном зохиолыг төлөвлөсөн ёсоор хугацаа хожимдуулалтгүй хэвлэн гаргасан байхыг улсын хэвлэл /Бямбажав/д даалгасугай.

д/ Монгол хуучин үсэг, Англи, Франц зэрэг латин үсгийн-тэмдэгтийг гадсад улсад захиалж 1959 оны 1-р улиралд багтаан ирүүлж ШУДБ Хүрээлөнд шилжүүлэн өхийг Худалдааны яам /н.Дэлгэржав/-т даалгасугай.

е/~~апп~~ хуралд зориулан хэвлүүлэх хуучин үсгийн 300 хэвлэлийн хуудас номыг Өвөр монголын Хөх хотын хэвлэлд захиаланд хэвлүүлж өхийг Соёлын яам /Сосорбарам/-д даалгахнаас гадна цаашдаа монгол улсын хэвлэх үйлдвэр, Хөх хотын хэвлэлийн хороо хоёрын

42

3.

хооронд байнгын харилцаа холбоотой бөлгөх талаар зохих
арга хэмжээ авахыг зүйтэй гэж үзсүгэй.



УЛС ТӨРИЙН ТОВЧООНЫ
ГНШУУД

Д. ДАМБА
Ю. ЦЭДЭНБАЛ
Ж. САМБУУ
Ч. СҮРЭНЖАВ
Ц. ДҮГЭРСҮРЭН
Б. ДАМДИН
Д. БАЛЖИННЯМ
Л. ЦЭНД
Д. ЛАМЧИН


Сүрэнжав

Дамдин

Дамдин

ОРЛОГЧ ГНШУУД

Д. САМДАН
Д. МОЛЮМЖАМЦ
Н. ЖАГВАРАЛ
Д. ТӨМӨР-ОЧИР
С. БАЛГАН



МОНГОЛ АРДЫН ХУВЬСГАЛТ
НАМЫН ТӨВ ХОРООНЫ УЛС ТӨРИЙН
ТОВЧООНЫ ХУРЛЫН ТОГТООЛ

1959 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр

№ 5 . .

Улаанбаатар хот

ОЛОН УЛСЫН МОНГОЛ ХЭЛ БИЧГИЙН
ЭРДЭМТЭДИЙН ИХ ХУРЛЫН БЭЛТГЭЛ АЖЛЫГ
ХАНГАХ БЭЛТГЭЛ ХОРОО БАМГУУЛАХ ТУХАЙ

1959 оны 9 дүгээр сард Улаанбаатар хотноо хуралдах олон улсын монгол хэл бичгийн эрдэмтэдийн их хурал нь монгол хэл бичгийн судмалд ихэвхэн хувь нэмэр оруулах бөгөөд манай орныг гадаадад сурталчилахад их ач холбогдолтойг харгалзаж, МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооноос ТОГТООХ НЬ:

1. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтэдийн их хурлын бэлтгэл ажлыг хангах зорилгоор МАХН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1958 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 321 дүгээр тогтоолоор батлагдсан монгол хэл бичгийн эрдэмтэдийн их хурлын бэлтгэл ажлыг хангах комиссыг өөрчилж, бэлтгэл хороо бодгон өөрчилсүгэй.

2. Олон улсын монгол хэл бичгийн эрдэмтэдийн их хурлын бэлтгэл хорооны бүрэлдэхүүнд:

Н. Цэгмид /дарга/
Н. Лувсандэндэв /нарийн бичгийн дарга/

Гяшүүдэд:

а. Н.Дамдинсүрэн
б. Н.Яаргалсайхан
в. Н.Ренчин
г. Н.Содном
д. Н.Найган
е. Н.Далан-Ажав Ажав
ё. Ш.Томь нарыг баталсугай.

3. Бэлтгэл хорооны ажлыг өдөр тутмын тодорхой удирдлагаар хангахыг нөхөр Сүрэнжав, Төмөр-Очир нарт даалгасугам.

УЛС ТӨРНИЙ ТОВЧООНЫ
ГҮНШҮҮД

Дамба
Ж. Самбуу
Сүрэнжав
Дүгэрсүрэн
Дамдин
Балжинням
Цэнд
Дамчин

Д. ДАМБА
Ю. ЦЭДЭНБАЛ
Ж. САМБУУ
С. СҮРЭНЖАН
Ц. ДҮГЭРСҮРЭН
Б. ДАМДИН
Д. БАЛЖИННЯМ
Ц. ЦЭНД
Д. ДАМЧИН

ОРЛОГЧ ГҮНШҮҮД

Дамдан
Моломжамц
Жагварал
Төмөр-Очир
Балган

Д. САМДАН
Д. МОЛОМЖАМЦ
Н. ЖАГВАРАЛ
Д. ТӨМӨР-ОЧИР
С. БАЛГАН

Монгол хэл бичгийн эрдэмтний
анхдугаар их хуралд гадаадаас урин
ирүүлэхээр төлөвлөсөн эрдэмтний
тухай товч тодорхойлолт

Америкаас:

Доктор профессор Кливез, Харвардын их сургуулийн монгол хэлний багш, нангиадч монголч /оросоор сино-монголист гэдэг мэрэгжилтэй/ бөгөөд дундад ард улсын шинжлэх ухааны түүхч эрдэмтэн Вань Ду зианы шавь, Дундад улсын нутгаас олдсон Юань улсын үеийн уйгаржин монгол үсгийн хэдэн бичгийг дэлхийд анх удаа тайлбарлан нийтлэж, англи хэлээр Америк Европод гардаг дорно дахиныг судлах сэтгүүлд удаа дараа хэвлэсэн нь, монгол эрдэмтэн бүхний гарын авлага болох сонин шинжлэл болжээ.

Кливезийн шинжлэл нь, монгол нангиад иран тулгар бичиг зэргийг маш нарийн харшуулж, хэлний шинжлэлийн нарийн задлал хийдгээр сонирхолтой бөгөөд, жишээлбэл, Монголын нууц товчоонд уг өгүүлбэрийн нарийн утгыг зуу гаруй жилийн турш европ, америк, азийн эрдэмтэн гүйцэд олоогүй зүйл үлэмж бийн дотроос, Кливезийн шинжлэлийн зүйлээр нэгэн тийш болсон асуудал олон бий.

Кливезийн тийнхүү дундад эртний монгол хэлний бичиг баримтыг шинжилсэн нь тухайн үед монголд үсгийн аялгуу дуудлага ямар байсныг нарийн магадлаж нягталснаар, хэлний шинжлэлтэн эрдэмтэн бүхэн, түүний бичсэн зүйлийг бахархан үздэг байна.

Энд ганц жишээ дурдвал Азийн судлалын Харвордын сэтгүүлд “Монголын нууц товчооноо “жеб эсэ бол” хэмээсэн үгийн утга учир” гэсэн арван тал хуудас хэмжээтэй өгүүлэлдээ герман Хениш, оросын Козин, Лам Палладий, арван гуравдугаар зууны үеийн хятад бичгийн хүмүүсийн тайлбар ухааралтад тэрхүү “нууц товчооноо” хоёрхон удаа гардаг “жеб эсэ бол” гэдэг үгийг хэрхэн ухаарснаас Толуйн амь нас хэрхэн болсныг шийдвэрлэх зүйл буйг шинжлэж, Толуйтай холбогдсон бүх түүх шастрыг улируулан байцааж, гэрч баримт болгон, хэлний шинжлэлийн өөрийн нутлалд хэрэглэж, түүхчин, хэлний шинжлэлтэн эрдэмтний зуун жил эргэлдсээр байсан үгийн учрыг олжээ.

Кливезны шинжлэн бичсэн зүйл, гол мэрэгжил нь арвангуравдугаар зууны үеийн монгол бичгийн хэл бөгөөд, энэ тухайд хорьдугаар зууны үеэс монгол хэлний дундад эртний үеийн байдлыг судлах талаар үлэмж бүтээл гаргасан эрдэмтэн Монголч нарын анхдугаар хуралд ч мөн энэ мэрэгжлийн хувьд хосгүй сонин илтгэл хийх байх гэж горьдоно.

Монгол хэлний түүхэн зүйг судлах ажилд Кливезийн бүх зохиолын ойрын хэдэн жилд орчуулан нийтлэх гэж, тэрхүү “жеб эсэ бол” гэдэг үгийн тухай өгүүлэлээс эхлэн орчуулж байдаг.

Кливезийн зохиол нь монголоор гарвал, манай их сургуулийн монгол хэл бичиг үзэж байгааг оюутанд монгол хэлний түүхийн хувьд туйлын чухал зүйл болно.

Мостерт гэдэг өвгөн эрдэмтэн, Арлингтонд одоо бий. Дэлхий дээр өвөр монголын гүйцэд судлагдаагүй нутгийн аялгууны хувьд ганцаараа байгаа эрдэмтэн. Түүний судлал шинжлэлийн зүйл, монголын судладаг эрдэмтэн бүхний гарын авлага болсон бөгөөд, Зөвлөлтийн монголч эрдэмтэн Владимирцов агсны бие, өвөр монголын

аялгууны шинжлэлд Мостертийг хосгүй хүн гэж маш үнэлдэг байжээ. Мостертийн ойд зориулан дурдахыг судлагч олон эрдэмтдээс тусгай боть зохиол гаргасан удаа ч бий.

Сүүлийн хэдэн жил, Сэцэн хун тайжийн эрдэнийн товчийг ордосоос олж өөрөө сийрүүлэн бичснээ шинжлэлийн нэг боть удиртгалын хамт хэвлүүлснэ. Бас манай алдарт Алтан товчийн зохиогчийн тухай, мөн түүнийг зохиосон он зэрэг маш чухал баримтыг олж хэвлүүлсэн зэрэг нэн олон зохиолтой бөгөөд, гадаад улсын олон монголч эрдэмтэн дунд Мостерт шиг сайхан монгол хэл бичигтэй хүн одоо хүртэл төрөөгүй. Монгол найруулгын хувьд манай одооны монгол залуу зохиолч нар, Мостертын дэргэд сая хэлэнд орж байгаа хүүхэд мэт гэж хэлэхэд дутнуу гэхээс хэтэрсэн үг болохгүй.

Мостертын шинжлэлийн зохиол Бээжин, Лейпциг, Брюсселд, Хзаг Хардвүрд зэрэг Ази Европын олон дорно дахиныг судлах дэлхийд нэрт сэтгүүл, цуврал бичиг, мөн тусгай дэвтэр зэрэг зүйлд дөчин жил хэвлэгдсээр ирсэн билээ.

Удо Пош доктор, профессор, Монгол хэлний зүйн тухай нилээд зохиол бичсэн бөгөөд сүүлийн үес буриадын бичгийн хэл бий болж байгааг шинжлэн бичсэн. Түүндээ жинхэнэ хэлний шинжлэлийн үүднээс задлан шинжилж, маш төв, жинхэнэ эрдэм шинжилгээний дүгнэлт хийсэн. Орчин үеийн монгол хэл аялгуут харшуулан шинжлэх ажил хийж буй тул, монголч нарын хуралд мөн хүү монгол хэлний шинжлэлийн авиа, үг зүйн асуудлаар илтгэл хийх болов уу гэж бодно.

Баруун Германаас: Хениш доктор профессор, одоо 80 хүрсэн хүн. Монголын нууц товчоог гучин илүү жил судалж, саган Сэцэн хун тайжийн эрдэнийн эрхийн нэгэн хувилбар эхийг саявтар нийтэлсэн. Бас Сингиан хавиас олдсон, мөн Иранаас олдсон дундад эртний монгол хэл бичгийн чухал баримтыг шинжлэн уншсан тухайгаа өгүүлэл нийтэлсэн хүн.

Тус хуралд бодвол, нэг насаар монголын дундад эртний тулгар бичгийг оролдож олсон шинэ зүйлээсээ илтгэл хийх болов уу гэж горьдоно.

Хейссиг доктор профессор шинэ цагийн монгол утга зохиолын түүхийг судлаж буй эрдэмтэн, шинэ цагийн утга зохиолыг чухал арван долдугаар зуунаас эхэлдэг үүнд Манж дайчин улсын үеийн монгол модон барын түүхэн шинжлэл нэгэн боть бичиж, хэдийд хаа, ямар хүний дурдсанаар хэн ямар хэлнээс орчуулсан буюу зохиосон зэргийг машид хүчин сүйтгэж магадлан олсон хувид тэр монгол модон барын түүх шинжлэл нь, арван есдүгээр зууны сүүлийн монголч Позднеевын зөвхөн дурдсан буюу дутуу шинжилсэн, олж мэдээгүй зүйлийг магадлан шинжилсэн тул, монгол зохиолын түүх судлах хүнд туйлын чухал ажил бүтээж өгсөн бөгөөд, одоо монгол утга зохиолын унших зохиол, залуусын хурим мөггөн хэгээст гэх зэрэг тулгар бичгийн он сар зэргийг нягтлан нийтлүүлж байгаа. Монголч эрдэмтний анхдугаар их хуралд хувьсгалын өмнөх монгол бичиг зохиолын тухай шинжлэн буй тухай илтгэл хийх болов уу гэж бодож байна.

Японоос: Хаттори Широ доктор, профессор, өвөр монголоос олсон монгол бичгийн дурсгал дундад эртний үеийн нангиад монгол бичгийн зүйлийг судалж буй тул мөн тэр тухайн зүйлийг илтгэх болов уу гэж бодно.

Ивамура профессор доктор, нууц товчооны хэл судалж буй тул, түүний тухай сонин илтгэл хийх байх гэж горьдож буй. Чингисийн чулууны бичгийг шинээр тайлбарласан сонин өгүүлэл нь Европын монголч эрдэмтэнд маш тоогдон буйг тэмдэглэлтэй. Тэр

Чингисийн чулууг зуу гаруй жил шинжилсэнд энэ Ивамура, одоо хүртэл сэжигтэй битүүлэг үгэнд шинэ тайлбар хийсэн билээ.

Озава, Абемац хоёр профессор монгол бичгийн хэлний зүйлийг оролдон буй тул, модон бар, бичмэл ном судрын зүйлээс мөн афганы монголчуудын хэлийг японы монголч нарын судалж байгаа тухай илтгэл хийх болов уу гэж бодож байна. Эдгээр есөн эрдэмтний зохиол, японоор маш олон буйн заримаас бид монгол болгохыг завдан буй.

Түркээс: профессор доктор Вахауддин. монгол, уйгар, хятад хэлний судлалтан. Түркээс монгол уйгар хэлний холбогдолтой буюу угсаатны зүйн сэдвээс илтгэл хийх болов уу гэж түүний мэрэгжлийн байдлаас таамаглан буй.

Англиас: Бодэн доктор арван долдугаараас есдүгээр зууны үеийн монгол бичиг зохиолын зүйлийг оролон буй тул, мөнхүү оролдон буй зүйлээр илтгэл хийх болов уу. Түүний хэвлэсэн зохиолоос Алтан товч гэдгийг саявтар орчуулгын хамтаар хэвлэж, бас Хейсигтэй нийлэн монгол утга зохиолын зарим тулгуур бичиг судалсан нь одоо хэвлэлд буй. Английн ганц монголч эрдэмтэн бөгөөд Англид монгол хэл анх зааж буй хүн болно.

К.Гренбех гэдэг скандиновын туркч-монголч эрдэмтэн агсантай нийлж бичсэн зүйл бас бий. боловч, эдгээр европ эрдэмтний зохиол гол төлөв 1938 оноос хойш энэ хорин жилд маш олон гарсан боловч манай улсын номын сан, монголын судлалын тухай эдгээр европын хэлээр гарч байгаа номоос олж авсан зүйл бараг байхгүй тул, энд нарийн тоочиж бичихийн аргагүй. Энэ талаар манай хэл зохиол судлах газар эс хөөцөлдвөл, монгол улсын доторх монголч нар арван есдүгээр зууны сүүлээр гарсан шинжлэлийн бичиг зохиолын хэмжээнээс хэтрэхгүй, тавь гаруй жил хоцрогдсон болоод байгааг дурдууштай байна.

Францаас: Луи Амбис- нангиадч монголч, Юан улсын судраас хэдэн боть Францаар сүүлийн хэдэн жилд гаргасан. Түүний зохиосон монгол хэлний зүйгээр франц европд монгол хэл үздэг Ярианы хэл огт мэдэхгүй гагцхүү монгол барын бичиг уншдаг хүн Монголч нарын хуралд өөрийн судлал буй хятад монгол тулгар бичгийн сэдвээр илтгэл хийх болов уу гэж бодно.

Финландаас: Пентти Аалто. мэрэгжил Алтайч хүн бөгөөд, Европын эрдэм шинжилгээний газрын монгол бичмэл, барламал номын гарчгий шинжилгээний ёсоор хийсэн мөн их монголч агсан Рамстедтын хэвлэн завдаагүй зохиолыг боловсруулан хэвлүүлсэн. Сингианаас арван есдүгээр зууны үес олдсон дөрвөлжин үсгийн номын тасархай олон эрдэмтэн шинжлэн бичснийг дахин шинжиж, Мажар эрдэмтэн Лигентийн олсон арван дөрөвдүгээр зууны эхний үеийн сувшидийн дөрвөлжин үсгийн хэвлэл мөн гэж танин олсоноор монголч эрдэмтэнд сүрхий сонин нээлт хийж өгсөн хүн. Ярианы хэл огт мэдэхгүй монгол-алтайн хэлний сэдвээр буюу Алтан гэрэл зэрэг судрын үг хэлийн тухай илтгэл хийж магадгүй.

Мажар улсаас: Лигети Лайош доктор, профессор, ардын засаг мандсанаас хойш манж хэл бичиг, монгол хэл бичиг, монгол хэлэнд эртний азийн улсын олон хэлтэй холбогдолтой соёлыг үг, Гэсрийн монгол ганжуурын гарчиг зэрэг чухал зүйл дэлхийн

монголч нарт зориулан голдуу франц хэлээр хэвлүүлсэн. Бас мажар хэлээр хэвлүүлсэн өгүүлэл олон бий.

Монголын өвөг болох хядан хэл бичиг, Афганистаны монголчуудын хэлний тухай биеэр цуглуулсан материал, арван гурав дөрөвдүгээр зууны зарим чухал тулгар бичгийг судлан буй тул, тэр тухай сонин илтгэл хийх болов уу гэж бодно.

Көөхалин Каталин доктор, монгол хэл, монгол хэлтэн аймгийн тухай ном, мөн төв Азийн морьтой нүүдэлчин аймгийн зэр зэвсгийн тухай монгол, манж бичиг тулгарын зүйл, мажар зэрэг улсын музейн цуглуулган зүйлийн шинжлэн маш чухал сонин өгүүлэл германаар нийтэлсэн бөгөөд, алтайн хэлний судлалын тухай хэвлүүлсэн зохиол нь турк манж хамниган хэлний зүйл, монгол хэлтэй холбогдолтойг шинжлэн үзүүлсэн сонин баримт гаргасан нь монгол хэлний зүйн талаар манж хамниган, олон турк хэлтний үгийн зүйн судлалд шинэ шинэ баримт оруулжээ. Дотооддоо зориулсан хэвлэлд мажар үсгээр, гадаадад зориулсан эрдэм шинжилгээний хэвлэлд германаар бичдэг хүн. Өнгөрсөн он монгол газраар явж цуглуулсан аман аялгуу, угсаатны судлалын тухай мажараар хэдэн өгүүлэл нийтэлж монгол турк хасаг хэлний харилцан холбогдолтой үг зүйн шинжлэлийн зүйлээр зохиол бэлтгэж буй тул, тэр тухай илтгэл, мөн угсаатны зүйн сэдвээр илтгэл хийх болов уу.

Афганистанд: монголч эрдэмтэн байхгүй боловч тэндэх монголчуудаас хүн ирвэл, бас тэр хөөрхий дарлагдсан монголчуудад дэмжлэг болж, Афганистанд монгол ард улсыг сурталчилахад тустай болов уу.

Польш, Ардчилсан Герман Чехословакт Солонгост нэр гарсан монголч эрдэмтэн, монголоор ярьдаг бичдэг хүн байхгүй, дөнгөж сая оролдож буй хүмүүс буй.

Энэтхэгт Рагу Вира доктор профессор Монгол хэлний зүйг энэтхэгээр зохион, Энэтхэгийн их сургуульд монгол хэл судлахын бэлтгэл хийж бас самгарди төвд монгол толь, төвд монгол даяг гэдэг дохионы бичгийн үндсээр хийж буй энэтхэгийн монголч ганц хүн болно.

Ринчен